

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Маньбадар	Дугаар	L334
Оршин суугаа аймаг	Дундговь аймаг	Оршин суугаа сум	Баянжаргалан сум
Төрсөн газар	Баянжаргалан сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Уулын жас	Сүм хийдийн дугаар	ДУГС 055
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 30	Ярилцлага авсан хүн	Жужа



Дундговь аймгийн Баянжаргалан сумын Уулын манбын жас

Жужа: Энэ нутагт Уулын жас гэж хаана байв?

Маньбадар: Сумын төвөөс баруун тийшээ гучаад км байна. Хажууд нь манай нутаг байдаг.

Жужа: Яг ямар нэртэй газар вэ?

Маньбадар: Уул гэдэг нэртэй газар. Бас сумаас хойшоо арван хоёр км газар Шуурган жас гэж байсан.

Жужа: Уулын жас хэдэн дугантай байсан?

Маньбадар: Гурван дугантай байсан.

Жужа: Хэдэн ламтай байсан бэ?

Маньбадар: 60, 70-аад ламтай байсан.

Жужа: Шуурган жас хэдэн дугантай байсан бэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Маньбадар: Ерөөсөө ганц дугантай.

Жужа: Хэдэн ламтай байсан?

Маньбадар: Нэг л тахилч лам байсан. Зул хүжийг нь асаагаад бурхан тахилыг арчиг сууж байдаг. Энэ чинь цагийн хурал шүү дээ. Тогтмол хурал хурдаггүй. Дүйчэн өдрүүдэд лам нар гарч ирж хурдаг.

Жужа: Лам нар хаанаас гарч ирэх вэ?

Маньбадар: Зүүн Чойроос гарч ирнэ.

Жужа: Энэ хийдийн дуганууд юугаар баригдсан байдаг вэ?

Маньбадар: Мод, шавар дуган л байсан байх.

Жужа: Энэ дуганууд гадуураа хэрмэн хашаатай байсан уу?

Маньбадар: Үгүй задгай байсан.

Жужа: Уулын жасад майдар эргэж байсан уу?

Маньбадар: Майдар эргэж байсан юм гэнэ лээ.

Жужа: Хайлан хүрж байсан уу?

Маньбадар: Үгүй ээ, хайлан хурдаггүй байсан.

Жужа: Та Гучинтын хурлын тухай сонссон уу?

Маньбадар: Сонсоогүй ээ, цагаан дэлгэрийн нутагт л байдаг байх.

Жужа: Дураатын хурлын тухай юм сонссон уу?

Маньбадар: Үгүй ээ, мэдэхгүй.

Жужа: Баруун Цоорын хурал гэж сонссон уу?

Маньбадар: Баруун Чойр уу?

Жужа: Үгүй ээ, Баруун Цоор?

Маньбадар: За мэдэхгүй юм байна. Баруун ганжүүр, зүүн ганжүүр, баруун Чойр, зүүн Чойр л гэж байсан.

Жужа: Уулын жас яг ямар нэртэй уулын тэнд байна?

Маньбадар: Дэлгэр уул гэж уулын өвөрт.

Жужа: Шуурган жас ямар нэртэй газар байна?

Маньбадар: Хар үзүүр гэдэг газар.

Жужа: За баярлалаа, таны нэг зургийг авъя.